

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: ОРА-2025/86/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Эрдэнэт хот  
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва  
Утас: 70353088, Цахим хаяг: [purevlkhagvar@audit.gov.mn](mailto:purevlkhagvar@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Буян-Ундрах  
Утас: 70355805, Цахим хаяг: [buyanundrakhb@audit.gov.mn](mailto:buyanundrakhb@audit.gov.mn)  
Аудитор: Б.Азжаргал  
Утас: 70357955, Цахим хаяг: [azjargalb@audit.gov.mn](mailto:azjargalb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.20 № 14  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  
Ц.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татаан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзэхээр байна.

**Аудитын гол асуудал**

Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 25.22 хувиар өссөн байна.

Энэ нь 2024 оны 03 сарын 27-ны өдрийн Монгол улсын Засгийн газрын 128 дугаар тогтоолоор "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээ"-г шинэчлэн тогтоож 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхэлсэн.

Мөн Монгол улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолын дагуу "Төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох журам"-г мөрдөж эхэлсэнтэй холбоотой байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн сайдтай хамтын ажиллагааны гуравласан гэрээ байгуулж, хэрэгжилтийг 95.3 хувьтай үнэлсэн байна.

Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх захиргааны байгууллагуудын хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 6 зорилт, 89 арга хэмжээг 96.6 хувьтай тус тус үнэлэгдсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



*(Handwritten signature)*

П.ПҮРЭВЛХАГВА

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	593,927,161.56	598,104,580.44
33	АВЛАГА	6,128,042.91	8,094,454.91
335	Бусад авлага	6,128,042.91	8,094,454.91
3351	Байгууллагаас авах авлага	2,338,990.82	4,305,402.82
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,789,052.09	3,789,052.09
35	БАРАА МАТЕРИАЛ	587,799,118.65	590,010,125.53
351	Түүхий эд материал	513,378,990.44	549,339,987.53
35110	Тусгай зориулалттай материал	151,857,349.76	144,027,598.23
35130	Эм боох материал	361,521,640.68	405,312,389.30
354	Хангамжийн материал	74,420,128.21	40,670,138.00
35410	Бичиг хэргийн материал	1,357,000.00	-
35420	Аж ахуйн материал	23,303,658.00	20,477,758.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,723,750.00	1,593,000.00
35440	Түлш, шатах тослох материал	22,045,000.00	4,190,000.00
35470	Бусад хангамжийн материал	20,990,720.21	14,409,380.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,938,681,747.69	7,327,398,156.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,938,681,747.69	7,327,398,156.77
392	Биет хөрөнгө	7,441,186,747.49	6,875,548,156.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,758,549,479.83	7,310,046,001.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	(566,277,378.88)	(628,019,813.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	203,616,434.00	183,616,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(151,290,545.82)	(142,664,189.26)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	504,879,545.89	474,808,151.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(347,110,103.64)	(352,364,224.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,976,324.84	62,735,473.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50,716,061.09)	(48,780,186.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,699,899.42	26,772,237.08
39215	Хуримтлагдсан элэгдэл	(14,140,847.06)	(10,601,726.90)
393	Биет бус хөрөнгө	497,495,000.20	451,850,000.00
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(749,999.80)	(750,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	497,495,000.00	451,850,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,532,608,909.25	7,925,502,737.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	575,100.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	575,100.00	-
413	Өглөг	575,100.00	-
4136	Бусад өглөг	575,100.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	575,100.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,532,033,809.25	7,925,502,737.21
51	Засгийн газрын хувь оролцоо	8,532,033,809.25	7,925,502,737.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,574,782,656.30	2,574,782,656.30

51101	Өмч: - төрийн	2,574,782,656.30	2,574,782,656.30
512	Хуримтлагдсан үр дүн	5,044,684,258.53	4,545,916,249.44
51210	Өмнөх үеийн үр дүн	5,044,684,258.53	5,152,447,321.48
51220	Тайлант үеийн үр дүн	-	(606,531,072.04)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	912,566,894.42	804,803,831.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,532,608,909.25	7,925,502,737.21

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,600,057,926.83	4,795,648,337.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	907,880,607.83	940,108,375.97
120	Нийтлэг татварын бус орлого	907,880,607.83	940,108,375.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	907,880,607.83	940,108,375.97
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	907,880,607.83	940,108,375.97
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,692,177,319.00	3,855,539,962.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,102,134,500.00	3,177,105,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,102,134,500.00	3,177,105,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	585,866,653.00	657,259,192.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,385,805.00	36,102,460.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	476,868,356.00	580,716,920.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	93,612,492.00	39,363,712.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,076,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,176,166.00	21,175,070.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,176,166.00	21,175,070.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,760,830,238.68	3,874,542,758.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,760,830,238.68	3,874,542,758.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,623,597,597.31	1,941,530,535.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	822,182,504.28	1,148,170,584.00
210101	Үндсэн цалин	457,526,479.98	610,832,254.00
210102	Нэмэгдэл	228,644,924.37	378,524,002.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	74,222,528.76	74,494,429.60
210104	Урамшуулал	61,788,571.17	84,319,898.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,568,124.74	152,235,839.60
210201	Тэтгэврийн даатгал	70,235,479.66	113,856,339.60
210202	Тэтгэмжийн даатгал	7,268,719.02	9,594,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,815,946.55	4,797,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,345,449.69	4,797,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,902,529.82	19,189,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,659,282.71	68,799,497.11
210301	Гэрэл, цахилгаан	8,506,669.96	10,186,402.47
210302	Түлш, халаалт	6,524,994.52	4,201,540.33

210303	Цэвэр, бохир ус	4,951,202.23	4,805,824.31
210304	Байрны түрээс	26,676,416.00	49,605,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,052,601.90	82,440,810.15
210401	Бичиг хэрэг	11,257,900.00	19,758,050.00
210402	Тээвэр, шатахуун	37,605,336.00	28,361,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,264,630.90	4,937,108.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,925,725.00	522,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,999,010.00	4,139,678.00
210408	Бараа материал акалсны зардал	-	24,722,573.95
2105	Нормативт зардал	112,523,175.03	62,148,986.18
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	66,753,235.03	15,370,086.18
210502	Хоол, хүнс	45,750,140.00	45,783,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,800.00	995,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,946,625.00	4,017,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,845,200.00	-
210604	Урсгал засвар	5,801,425.00	4,017,250.00
2107	Томилолт, зочны зардал	25,689,400.00	19,505,400.00
210702	Дотоод албан томилолт	25,689,400.00	19,505,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	236,539,630.00	193,494,306.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	218,888,300.00	189,514,376.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,752,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	294,030.00	700,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,200.00	103,730.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	545,000.00	2,184,000.00
210807	Газрын төлбөр	14,907,100.00	947,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	206,436,253.65	210,717,862.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,770,700.00	14,448,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	875,000.00	21,163,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	194,790,553.65	175,105,312.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,137,232,641.37	1,933,012,223.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,123,757,774.00	1,892,332,670.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,176,166.00	21,175,070.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	605,870,400.00	946,181,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	487,202,600.00	906,166,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,508,608.00	18,810,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,474,867.37	40,679,553.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,474,867.37	40,679,553.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	839,227,688.15	921,105,579.65
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,188,576,677.11	1,527,636,651.69
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	201,910,189.94	550,959,398.73
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	986,666,487.17	976,677,252.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,188,576,677.11)	(1,527,636,651.69)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(349,348,988.96)	(606,531,072.04)

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,692,177,319.00	3,855,539,962.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,692,177,319.00	3,855,539,962.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,102,134,500.00	3,177,105,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,102,134,500.00	3,177,105,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	585,866,653.00	657,259,192.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,385,805.00	36,102,460.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	476,868,356.00	580,716,920.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	93,612,492.00	39,363,712.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,076,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,176,166.00	21,175,070.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,176,166.00	21,175,070.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,694,487,455.00	3,855,539,962.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,694,487,455.00	3,855,539,962.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,555,924,713.63	1,920,707,738.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	822,182,504.28	1,147,969,234.00
210101	Үндсэн цалин	457,526,479.98	610,630,904.00
210102	Нэмэгдэл	228,644,924.37	378,524,002.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	74,222,528.76	74,494,429.60
210104	Урамшуулал	61,788,571.17	84,319,898.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,568,124.74	155,278,351.60
210201	Тэтгэврийн даатгал	70,235,479.66	116,898,851.60
210202	Тэтгэмжийн даатгал	7,268,719.02	9,594,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,815,946.55	4,797,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,345,449.69	4,797,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,902,529.82	19,189,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,659,282.71	68,799,497.11
210301	Гэрэл, цахилгаан	8,506,669.96	10,186,402.47
210302	Түлш, халаалт	6,524,994.52	4,201,540.33
210303	Цэвэр, бохир ус	4,951,202.23	4,805,824.31
210304	Байрны түрээс	26,676,416.00	49,605,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	83,348,696.90	60,746,470.20
210401	Бичиг хэрэг	14,742,600.00	16,916,560.00
210402	Тээвэр, шатахуун	51,305,431.00	34,004,472.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,264,630.90	5,852,108.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,925,725.00	522,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,110,310.00	3,451,330.00
2105	Нормативт зардал	177,079,400.00	206,867,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	129,160,560.00	165,274,000.00
210502	Хоол, хүнс	47,376,740.00	41,521,500.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	542,100.00	71,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,567,875.00	22,562,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,624,400.00	16,365,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,736,300.00	1,241,500.00
210604	Урсгал засвар	5,207,175.00	4,955,500.00
2107	Томилолт, зочны зардал	25,689,400.00	19,505,400.00
210702	Дотоод албан томилолт	25,689,400.00	19,505,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	245,584,030.00	201,928,906.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225,992,800.00	198,195,276.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,752,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	294,030.00	700,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,200.00	103,730.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,484,900.00	1,937,700.00
210807	Газрын төлбөр	14,907,100.00	947,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,245,400.00	37,050,880.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,395,400.00	13,998,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,850,000.00	23,052,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,138,562,741.37	1,934,832,223.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,124,011,774.00	1,894,152,670.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,176,166.00	21,175,070.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	605,870,400.00	946,181,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	487,202,600.00	906,166,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,762,608.00	20,630,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,550,967.37	40,679,553.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,550,967.37	40,679,553.09

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,574,782,656.30	912,566,894.42	5,044,684,258.53	8,532,033,809.25
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,574,782,656.30	912,566,894.42	5,044,684,258.53	8,532,033,809.25
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,574,782,656.30	912,566,894.42	5,044,684,258.53	8,532,033,809.25
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,574,782,656.30	912,566,894.42	5,044,684,258.53	8,532,033,809.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн			107,763,062.95	107,763,062.95

	бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,574,782,656.30	912,566,894.42	5,152,447,321.48	8,639,796,872.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(107,763,062.95)	-	(107,763,062.95)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(606,531,072.04)	(606,531,072.04)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,574,782,656.30	804,803,831.47	4,545,916,249.44	7,925,502,737.21

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,177,105,700.0	3,136,426,146.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,177,105,700.0	3,136,426,146.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,281,672,300.0	1,281,283,546.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	990,988,700.0	990,988,700.0
210101	Үндсэн цалин	617,593,200.0	610,630,904.0
210102	Нэмэгдэл	237,112,700.0	221,543,468.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,400,900.0	74,494,429.6
210104	Урамшуулал	77,881,900.0	84,319,898.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,036,000.0	135,670,141.6
210201	Тэтгэврийн даатгал	97,656,500.0	97,290,641.6
210202	Тэтгэмжийн даатгал	9,594,900.0	9,594,900.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,797,400.0	4,797,400.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,797,400.0	4,797,400.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,189,800.0	19,189,800.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,799,500.0	68,799,497.1
210301	Гэрэл, цахилгаан	13,198,200.0	10,186,402.5
210302	Түлш, халаалт	9,059,300.0	4,201,540.3
210303	Цэвэр, бохир ус	11,669,900.0	4,805,824.3
210304	Байрны түрээс	34,872,100.0	49,605,730.0
2104	Хангамж, бараа материалын зардал	24,701,000.0	24,700,998.2
210401	Бичиг хэрэг	6,037,200.0	3,434,710.0
210402	Тээвэр, шатахуун	13,316,800.0	13,316,800.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,373,500.0	4,455,508.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	731,800.0	324,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,241,700.0	3,169,980.0
2105	Нормативт зардал	71,500.0	71,500.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	71,500.0	71,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,977,000.0	4,977,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,241,500.0	1,241,500.0
210604	Урсгал засвар	3,735,500.0	3,735,500.0
2107	Томиллолт, зочны зардал	12,815,400.0	12,815,400.0
210702	Дотоод албан томилолт	12,815,400.0	12,815,400.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,069,300.0	8,058,630.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,328,700.0	4,325,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	700,700.0	700,700.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,100.0	103,730.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	47,600.0	44,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,937,700.0	1,937,700.0
210807	Газрын төлбөр	947,500.0	947,500.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,213,900.0	35,201,680.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,010,600.0	13,998,380.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,203,300.0	21,203,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,895,433,400.0	1,855,142,600.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,895,433,400.0	1,855,142,600.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	961,493,900.0	946,181,100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	931,124,000.0	906,166,500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,815,500.0	2,795,000.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,177,105,700.0</b>	<b>3,177,105,700.0</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,177,105,700.0</b>	<b>3,177,105,700.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,177,105,700.0	3,177,105,700.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	
		2023.12.31	2024.12.31
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	586,441,453.0	657,259,192.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	586,441,453.0	657,259,192.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	586,441,453.0	657,259,192.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	81,136,961.0	156,980,534.0
210102	Нэмэгдэл	81,136,961.0	156,980,534.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,387,395.0	19,608,210.0
210201	Тэтгэврийн даатгал	7,387,395.0	19,608,210.0
2104	Хангамж, бараа материалын зардал	55,389,197.0	36,045,472.0
210401	Бичиг хэрэг	8,705,400.0	13,481,850.0
210402	Тээвэр, шатахуун	37,893,797.0	20,687,672.0
210403	Шуудан холбоо	6,421,000.0	1,396,600.0
210405	Хог хаягдал	2,369,000.0	198,000.0
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл		281,350.0
2105	Нормативт зардал	176,537,300.0	206,795,500.0
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	129,160,560.0	165,274,000.0
210502	Хоол хүнс	47,376,740.0	41,521,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,470,800.0	17,585,000.0
210601	Багаж хэрэгсэл худалдан авах		16,365,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын зардал	7,470,800.0	0

210604	Урсгал засварын зардал		1,220,000.0
2107	Томилолт, зочны зардал	15,176,000.0	6,690,000.0
210702	Дотоод албан томилолт	15,176,000.0	6,690,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	221,580,300.0	193,870,276.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	221,580,300.0	193,870,276.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,214,700.0	1,849,200.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,214,700.0	1,849,200.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,549,100.0	17,835,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,473,000.0	17,835,000.0
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,076,100.0	0
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	586,441,753.0	657,259,192.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс авсан хандив, тусламж	15,385,805.0	36,102,460.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	476,868,356.0	580,716,920.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	93,612,492.0	39,363,712.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	575,100.0	1,076,100.0

## Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 33,609.4 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 842.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 14,889.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 17,877.4 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж хүргүүлсэн.

### Залруулсан алдаа:

2024 оны санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

### 5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тушаал шийдвэргүй 319.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт: Албан хаагчийн хоол, унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан 522.5 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 61.1.3-д "Гүйцэтгэж байгаа албан

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үүргийн шинж байдлаас хамааран зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах төрийн тээврийн хэрэгслийн зардлын зохих хэсгийг нөхөн авах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2.2-д "албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ", 2.2.1-д "унааны зардал", 2.2.2-д "байрны зардал", 2.2.3-д "хоолны зардал", 8.4-д "Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

## **5.2 Албан шаардлага**

Илрүүлэлт: Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн нийт 14,889.8 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.3-д "Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-д "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 1.2.1-д "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд", 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.

## **5.3 Зөвлөмж**

Илрүүлэлт: Илүү цагийн нэмэгдэл олгохдоо тухайн сард нь тооцож олголгүй 7, 8 сарыг хамтатган 10 хувиас хэтрүүлэлгүйгээр 8,635.8 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын"-ын 4.1-д "улс орныг батлан хамгаалах, хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалах", 3-д "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна." гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Нэмэгдэл хөлсийг баримт нотолгоонд тулгуурлан тухай бүрд нь олгож байх.

Илрүүлэлт: Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөлтгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр тооцож 6,199.1 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Зам тээврийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 тушаалтай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Шатахууныг нормоос илүү тооцож олгосон зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх

Илрүүлэлт: Автомашин, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийн хувийн хэрэг хөтлөөгүй, тайлант онд гарсан өөрчлөлтийг хувийн хэрэгт тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-тай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Эд хөрөнгийн хувийн хэрэг хөтлөх, тайлант онд гарсан өөрчлөлтийг бүртгэлд тусгаж хэвших.

Илрүүлэлт: Худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д " хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Бараа, ажил, үйлчилгээний анхан шатны баримтыг холбогдох хууль, журамд нийцүүлж, бүртгэж тайлагнах.

Илрүүлэлт: Тайлант онд аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 3,042.5 мянган төгрөгийн авлага үүсгэн ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс	8	33.6	2	0.8	1	14.9	5	17.8	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>33.6</b>	<b>2</b>	<b>0.8</b>	<b>1</b>	<b>14.9</b>	<b>5</b>	<b>17.8</b>				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
<b>НИЙТ</b>		<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			